



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 02.

Ховд

Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан  
сэргийлэх вакцины хамралтыг эрчимжүүлэх тухай

Ховд аймагт Коронавируст халдвар /Ковид-19/-ын анхны тохиолдол 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдөр бүртгэгдэж Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар халдварыг цомхотгох олон талт арга хэмжээг авч ажиллаж байна.

Улсын хэмжээнд халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх үндсэн арга болсон иргэдийг вакцинжуулах үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд аймгийн хэмжээнд 18 ба түүнээс дээш насны 54241 иргэн вакцинд хамрагдахаас 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар урьдчилсан байдлаар нэгдүгээр тунд 43145, хоёрдугаар тунд 20136 хүн хамрагдаж нэгдүгээр тунгийн хамралт 85.19, хоёрдугаар тунгийн хамралт хамралт 39.74 тус тус байгаа бөгөөд 80-аас дээш хувийн хамрагдалтай Жаргалант, Дарви, Алтай, Буянт сумууд байгаа бол 70-аас доогуур хувийн хамралттай Дуут, Үенч, Дөргөн, Манхан сумдууд байна.

Сүүлийн өдрүүдэд сум, өрхийн Эрүүл мэндийн төвөөр вакцинжуулалтанд хамрагдах иргэдийн тоо буурах, хамралт нэмэгдэхгүй байх нь ажиглагдаж байна.

Иймд вакцинжуулалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд эрчимжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.7, 1.8 дахь заалтууд, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.4 дэх заалтуудыг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Аймгийн Онцгой комисс, вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт:

1.1. Аймгийн хэмжээнд вакцинжуулалтын хамралт, явцын байдалтай танилцаж, вакцины хамрагдалтыг эрчимжүүлэх ажлын хэсгийг сумдад томилон ажиллуулах,

1.2. Төвлөрүүлэн татан авч байгаа вакцины хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавьж, эсрэг заалтаар вакцинд хамрагдаагүй иргэдийг өөр үйлдвэрийн вакцинаар вакцинжуулах, аймгийн вакцины нөөцийг бүрдүүлж ажиллах,

Хоёр. Сумдын Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга нарт:

2.1. Иргэдийг дархлаажуулалтанд бүрэн хамруулах ажлын төлөвлөгөөг сум, орон нутгийн онцлогтой уялдуулан өөрчлөлт оруулах замаар вакцинжуулалтаас хоцорч буй иргэдийг яаралтай хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч, 18 ба түүнээс дээш насны бүх хүн амыг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор бүрэн дархлаажуулж дуусгах,

2.2. Дархлаажуулалтын хамралтын хувь улсын дунджаас доогуур түвшинд байгаад дүгнэлт хийж, байнгын болон түр оршин суугч, өөрийн хаяг дээрээ байхгүй, өөр газар вакцинжуулалтанд хамрагдсан иргэдийн судалгааг хүснэгтээр нарийвчлан гаргаж, [odkhuu1209@gmail.com](mailto:odkhuu1209@gmail.com), [sodrij@yahoo.com](mailto:sodrij@yahoo.com) хаягаар 2021 оны 06 дугаар сарын 07-ны дотор ирүүлэх,

2.3. Сумын дархлаажуулалтын ажлын явцын мэдээ, тайланг вакцины ажлын хэсэг, сумын Онцгой комиссын хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээг эрчимжүүлэх, явуулын баг томилон багийн малчид, иргэдийг вакцинд бүрэн хамруулах арга хэмжээг авах, шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх,

2.4. Сумын Эрүүл мэндийн байгуулагуудын ард иргэдийн вакцинжуулах үйл ажиллагаатай тогтмол танилцаж, тулгамдсан асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, вакцины хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж, аюулгүй байдлыг хангаж ажиллах,

2.5. Иргэдийг вакцины бүрэн тунд хамрагдах талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг орон нутагт чанартай зохион байгуулахад төр, иргэний нийгэм, иргэдийн оролцоог дээшлүүлж, мэдээллээр хангаж ажиллах,

Гурав. Эрүүл мэндийн газрын дарга, Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд:

3.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын дархлаажуулалтын хамралтын тайланг аймгийн вакцинжуулалтын ажлын хэсэг, Онцгой комиссын шуурхай штаб, холбогдох удирдлагуудад хүргүүлж, вакцинжуулалтыг эрчимжүүлэхэд хүндрэл учруулж буй асуудлуудыг цаг алдалгүй танилцуулан шийдвэрлүүлж ажиллах,

3.2. Дархлаажуулалтын 1, 2 дугаар тунгаа авсан иргэдийг цахим бүртгэлд хамруулах, шаардлагатай мэдээллийг нэгтгэж, тайланг холбогдох дээд шатны байгууллагад үнэн зөв бодитой мэдээлэх,

3.3. Дархлаажуулалтын үйл ажиллагааны явцад үүсэж буй эмнэлгийн болон бусад хог хаягдлыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 тоот тушаалын дагуу устгалд оруулах,


3.4. Вакцинжуулалтанд хамрагдахгүй эсрэг заалттай иргэдийн судалгааг нарийвчлан гаргаж, odkhuu1209@gmail.com хаягаар хүснэгтээр гаргаж 2021 оны 06 дугаар сарын 07-ны дотор ирүүлэх,

3.5. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх вакцины ач холбогдол, вакцинд хамруулах талаарх мэдээлэл, сурталчилгааг хэвлэл мэдээллийн байгууллага, сайтуудаар иргэдэд сурталчлан таниулах арга хэмжээг авах,

3.6. Зорилтот бүлгүүд ялангуяа 0-18 насны хүүхдүүдийн халдвараас урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, ойр дотны хүмүүсээ халдвараас хамгаалах чиглэлийн арга зүйн зөвлөгөө зөвлөмжүүдийг иргэд, олон нийтэд тогтмол сурталчлах,

Дөрөв. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж, дархлаажуулалтын хамралтыг орон нутагтаа чанартай, өндөр зохион байгуулалттай хийж гүйцэтгэхийг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/, Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН